

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 07 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний хагас жилийн байдлаар дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор (ЗГ-ын 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон) батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д, нэмэлт өөрчлөлт орсон 374 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 48 арга хэмжээний гүйцэтгэлд 2023.07.09-ний өдөр үр дүнд суурилсан явцын дүн шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7-т заасныг баримтлан /... байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлалыг тус тус баримттална./

тус журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар тооцсон болно.

6.2.1.Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ;

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

6.2.2.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно;

6.2.2.1.Зорилт арга хэмжээний хүрэх түвшинд хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан , гол үр дүн гарч эхэлж байгаа бол 90.0%

6.2.2.2.тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь

6.2.2.3.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь

6.2.2.4.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30.0 хувь

6.2.2.5.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгааг хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь

6.2.3.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно.

6.2.3.1. **"Үр дүнтэй"**-зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100%;

6.2.3.2. **"Тодорхой үр дүнд хүрсэн"**-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь;

6.2.3.3. **"эрчимжүүлэх шаардлагатай"**-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтот чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 30-70 хүртэл хувь;

6.2.3.4. **"үр дүнгүй"**-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

Тайлангийн хэрэгжилтийг тооцохдоо тайлант хугацааг 2023.12.31-ний хүртэлх хугацааг 100 хувиар тооцож, 0-100 хувиар үнэлсэн болно.

1.Хэрэгжилт, үнэлгээ

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланд Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилтын 11 арга хэмжээ, нийтлэг чиг үүргийн 1 зорилтын 17 арга хэмжээ, дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 1 зорилтын 14 арга хэмжээ, төрийн албаны чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилтын 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан ба нийт 48 арга хэмжээнээс 42 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 48.5% -ийн явцтай (Эрчимжүүлэх шаардлагатай) үнэлэгдэв.

Хариуцах арга хэмжээг хэлтсээр харуулбал:

№	Арга хэмжээ	Зорилгын тоо	Арга хэмжээний тоо	Нийт арга хэмжээнд эзлэх хувь
1	Захиргаа, төлөвлөлт хуулийн хэлтэс	1	25	52.08%
2	Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний хэлтэс	1	7	14.05%
3	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс	1	4	8.3%
4	Хамтран хэрэгжүүлэх	4	12	25%
Нийт			48	

Хэрэгжилтийн дундаж үнэлгээ бүрийг бүлгээр харуулбал:

№	Арга хэмжээ	Зорилгын тоо	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ, хувь
1	Нэг.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	1	11	44.5%
2	Хоёр.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	17	51.1%
2	Гурав.Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ	1	14	48.5%
3	Дөрөв.Төрийн албаны чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	1	2	50%
	Хугацаа болоогүй		4	-
Нийт		4	48	

Нийт арга хэмжээний хэрэгжилтийг хувиар харуулбал:

№	Аргачлал	Хувь	Арга хэмжээний тоо
1	Зорилт арга хэмжээний хүрэх түвшинд хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлж байгаа бол	90.0%	0
2	Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол	70.0%	6
2	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол	50.0%	27
3	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол	30.0%	9
4	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгааг хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол	0%	0
Дундаж хувь		48.5%	42

Арга хэмжээ тус бүрийн дүн шинжилгээ, үнэлгээ

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
1	2	3	4	5
Зорилт 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх,				
1	1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, байгууллагын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжих	ЗТХХ	/Байгууллагын худалдан авалтаас зөвхөн зоогийн газрын бараа материал худалдан авалтын талаар тайлагнасан. Нийт тендер, худалдан авалтын талаарх мэдээллийг бүрэн оруулаагүй./	30%
2	1.2.“Хурлын танхим захиалгын систем” цахим цэсийг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлж цэсээр захиалгыг хүлээн авах, шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр хийж гүйцэтгэх	ҮҮА ИБАҮА	Тайлант хугацаанд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем https://erp.ulaanbaatar.mn -д “Хурлын танхим захиалгын систем” нэртэй цэсээр хурлын заалны захиалгыг цахимаар хүлээн авч мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. /Хурлын заалны захиалгыг цахимаар хэдэн байгууллагаас авч үйлчилсэн талаар тоон мэдээллийг багтаах, хөгжүүлэлт хэдэн удаа хэрхэн хийгдсэн болон хэдэн төгрөгийн санхүүжилт гаргасан тухай тоон талаар мэдээлэлгүй/	50%
3	1.3.Албан бичгийг тоон гарын үсгээр илгээх, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулж хэвшүүлэх, зөрчлийн тоог бууруулах	ЗТСХ	Архив, албан хэрэг хөтлөлт, төсөв санхүүгийн ил тод байдлын талаарх арга хэмжээг оруулж өгсөн нь төлөвлөлтийн алдаа бөгөөд угтаа “Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг” буюу төрийн бүх байгууллагад хамаарах нийтлэг арга хэмжээнд төлөвлөх юм. Мөн 2.12 арга хэмжээтэй ижил угта агуулгатай	30%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			байна. “eDOC” системийн баримт боловсруулалт модулийг ашиглан нийт 130 албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан илгээж ажиллалаа. /Уг арга хэмжээний хэрэгжсэн эсэхийг шалгах шалгуур үзүүлэлтээ зөрчлийн тоо гэсэн боловч хэрэгжилтийн тайланд зөрчлийн талаар мэдээлэлгүй./	
4	1.4.НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий орчныг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	ҮҮА, ИБАҮА	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран ажиллах хүсэлт гаргаснаар 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэжилтнийг “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт байр хариуцсан менежерүүд, инженерүүд зэрэг нийт 21 ажилтан, албан хаагч хамрагдсан. Сургалтын үеэр дээрх газрын хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга Б.Амаржаргал 4 ширхэг тэргэнцрийг хүлээлгэн өгснийг Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр болон НЗЗ-ны 1, 2, 5А дугаар байруудад тус тус хуваарилж байршуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээг авахад ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.	50%
5	1.5.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах журмын дагуу мэдээллийг цахим системд цаг хугацаанд байршуулж хэвших	ЗТСХ	Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-нд буюу нийт 5 удаа гарган Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст, албан хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст хуулийн хугацаанд нь буюу нийт 5 удаа явуулж баталгаажуулсан. <i>/Шилэн дансны цахим хуудсанд төсөв санхүүгийн ил тод байдалтай холбоотой хэдэн төрлийн мэдээ ямар хугацаанд тавигдахаас хэдэн удаагийн нийт хэдэн мэдээлэл тавигдсан талаарх тоон мэдээлэлгүй тайлагнаагүй, оновчтой мэдээлэл байхгүй./</i> <i>Тус арга хэмжээ нь 2.5-д заасантай утга ижил, агуулгаараа давхцсан тус нэгтгэн төлөвлөдөг байх!</i>	30%
6	1.6.Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	ЗТСХ	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд мэдлэг олгохоор Хууль эрх зүй - Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Ю.Хүслэн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр “Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт авлигын	30%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад нийт 170 ажилтан, албан хаагч хамрагдлаа. /Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний тоо, 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн хувь тайлагнаагүй/ Арга хэмжээ 1.6, 1.10, 2.7- Ижил утга агуулгатай арга хэмжээг нэгтгэн төлөвлөөгүй.	
7	1.7.Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран байгууллагын ажилтан, албан хаагчдыг ажил үүргийн чиглэлээр сургалтад хамруулах	ЗТСХ	Тайлант хугацаанд Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан нийт 6 сургалтад ажил үүргийн чиглэлээр давхардсан тоогоор нийт 214 ажилтан, албан хаагч хамруулсан. /Үр дүнг тооцоогүй, байгууллагын сургалтын төлөвлөгөөнд хэдэн арга хэмжээ төлөвлөсөн болон хэрэгжилтийн хувь тайлагнаагүй.	50%
8	1.8.Чанарын менежментийн тогтолцоо–Шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг үе шаттай эхлүүлэх ажлыг зохион байгуулах	ЗТСХ ҮҮА, ИБАҮА	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/11, 17 дугаар тушаал, газрын даргын “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/12 дугаар тушаалаар, А/14 дүгээр тушаалаар “Чанарын менежментийн тогтолцооны MNS 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөө”-г тус тус батлуулсан. “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-ын зөвлөх багш Б.Анхзаяатай хамтран хэрэгжилтийг ханган нарийвчилсан төлөвлөгөөний төлөвлөх үе шатны 10 бүлгийн 19 багц сургалтад нийт 147 ажилтан, албан хаагч хамрагдаж, зохих ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэсэн. Стандарт нэвтрүүлэх ажлын явцын шинжилгээ, хэрэгжүүлэх үе шат 69 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70%
9	1.9.“Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS0201B:2020 удирдамж арга зүйн баримт бичгийг цэвэрлэгээ, үйлчилгээндээ мөрдлөг болгон ажиллах, сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулах	ҮҮА	Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байрны нийт 61.395м.кв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" стандартыг мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна. Мөн 2023 онд шинээр ажилд орсон нийт 23 үйлчилгээний ажилтанд дээрх стандартыг танилцуулах ажлыг тухай бүрд нь зохион байгуулсан.	50%
10	1.10.Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион	ЗТСХ	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
	байгуулах 2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах		хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалын 9 албан хаагч Авлигатай тэмцэх газарт заасан хугацаанд ХАСХОМ-ээ мэдүүлсэн. <i>/Хэдэн арга хэмжээг төлөвлөснөөс хэрэгжилтийн явцын хувийг тайлагнах/</i>	
11	1.11.Найрсаг Улаанбаатар арга хэмжээний хүрээнд ажилтан, албан хаагчдын дунд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж хотын соёлыг дэлгэрүүлэх, ёс зүйг сайжруулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	ЗТСХ	Ажилтан, албан хаагчдын дунд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор спортын дөрвөн төрөлт тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, нийт 10 багийн 290 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин идэвхтэй оролцсон. Тэмцээнд оролцсон багуудаас нийлбэр дүнгээрээ тэргүүн байранд НЗЗ-ны 2 дугаар байрны “Хангарди” баг шалгарч “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ - 2023”-ын эзэн болсон бол дэд байранд ЗТСХ-ийн “Galaxy” баг, гутгаар байранд ННЗТЦБ-ны “Golden team” баг тус тус шалгарсан. Мөн найм дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Улаанбаатар Марафон - 2023” олон улсын гүйлтийн тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж, тус арга хэмжээнд байгууллагын нийт 16 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцлоо.	50%
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт				
12	2.1.Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах, баяжуулалтыг цаг тухайд нь хийх, холбогдох судалгааг тухай бүр гаргах	ЗТСХ	Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж, шинээр томилогдсон 45 ажилтан, албан хаагчид хувийн хэрэг үүсгэх, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хувийн хэргийн бүрдлийг ханган ажилласан. Тайлант хугацаанд хүний нөөцийн нэгдсэн www.hr.csc.gov.mn системд ажилтан, албан хаагчдын албан тушаал, үндсэн цалин, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ажил хавсран гүйцэтгэсэн, шинээр ажилд орсон ажилтан, албан хаагчдын хувийн шилжих хөдөлгөөнийг бүртгэж, тухай бүр шинэчилж оруулсан. Хүний нөөцийн чиглэлээр холбогдох нийт 17 судалгааг шинэчлэн нэгтгэсэн.	50%
13	2.2.Сул орон тоог тогтмол зарлах холбогдох хууль, журмын дагуу нөхөн бүрдүүлэлт хийх	ЗТСХ	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn ,	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуцах хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			www.biznetwork.mn байгууллагын мэдээллийн самбарт тус тус тогтмол байршуулж ажиллалаа. Мөн Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажлын байрны сул орон тооны зарыг тогтмол хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 13 ажлын байрны 37 сул орон тоонд 61 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн, бөгөөд анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж нийт 45 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн ажлын байрны сул орон тоонд зохих шаардлагыг хангасан 4 ажилтныг албан тушаалд дэвшүүлэн томилсон.	
14	2.3.Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хагас жилээр дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх	ЗТСХ	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 тогтоол, тус газрын “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу газрын даргын 2023 оны А/28 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдон ажилтан, албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын 2022 оны 4-р улирал, 1, 2-р улирлын үр дүнг дүгнэн, үр чадварын нэмэгдлийг сар бүр тооцон нийт 235306,9 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон.	50%
15	2.4.Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, сургалт, нийгмийн баталгааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	ЗТСХ	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу 7 ажилтан, албан хаагчид байгууллагад гаргасан хүсэлтийг нь үндэслэн нийт 3,400,0 мянган төгрөг, Цагаан сараар нийт 105 өндөр настанд Ахмадын насны тухай хуульд заасны дагуу хүндэтгэл үзүүлэх зардалд 5,250.0 мянган төгрөгийг, өндөр настны тэтгэвэрт гарсан нийт 3 ажилтан, албан хаагчид Татварын хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмжид нийт 45,201.3 мянган төгрөгийг мөнгөн тусламж тус тус үзүүлсэн. Тайлант хугацаанд байгууллагын сургалт, нийгмийн баталгааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 25 арга хэмжээний 19 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	70%
16	2.5.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь	ЗТСХ	Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-нд буюу нийт 5 удаа гарган Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст, ННҮГ-ын ажилтан, албан	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуцах хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
	тайлагнаж ажиллах		хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст хуулийн хугацаанд нь буюу нийт 5 удаа явуулж баталгаажуулсан. Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу зарцуулж, холбогдох 19 төрлийн тайлан мэдээг 126 удаа үнэн зөв, бодитой гарган, www.shilendans.gov.mn хуудаст тухай бүрд нь байршуулсан. <i>/Тус арга хэмжээ нь 1.5-д заасантай утга ижил, агуулгаараа давхцсан тус нэгтгэн төлөвлөж байх/</i>	
17	2.6.Байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг цаг тухай бүр нь олгох	ЗТСХ	ТАЦНС-д нийт ажилтан, албан хаагчдын цалингийн тооцоо, бүртгэл мэдээлэл, холбогдох тушаал шийдвэрийн дагуу программд оруулан тооцоолол хийж тайлант хугацаанд нийт 10 удаа цалин олгосон. Нийгмийн даатгалын тайланг нийт 5 удаа тайлагнан, ЧД-ийн нийгмийн даатгалд цаасан сууриар хүргүүлж баталгаажуулсан. Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын ажилласан жилийн нэмэгдэл болох 81907,8 мянган төгрөг, унаа, хоолны зардлын 283160,1 мянган төгрөг, ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэлд 235306,9 мянган төгрөгийг тус тус олгон ажиллалаа	70%
18	2.7.2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах	ЗТСХ	<i>Арга хэмжээ 1.6, 1.10, 2.7- Ижил утга агуулгатай арга хэмжээг нэгтгэн төлөвлөөгүй. /Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний тоо, 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн хувь тайлагнаагүй/</i>	50%
19	2.8.Байгууллагын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйг сахиулах	ЗТСХ	Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 3 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнээс сахилгын зөрчил 3 байгаагаас газрын даргын 2023 оны Б/81 дүгээр тушаалаар 1 ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.5 дахь заалтын дагуу ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалж, 2 албан хаагчид Б/131 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 123.3.2 дахь заалтын дагуу сахилгын шийтгэл ногдуулсан.	70%
20	2.9.Байгууллагын болон нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллах	ЗТСХ	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу дараах байдлаар байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Тухайлбал: - Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан удирдамжийн дагуу НЗЗ-ны байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэн хяналт шалгалтаар илэрсэн	30%

Д/д	Арга хэмжээ	Хариуцах хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			<p>зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулсан;</p> <p>- Газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 7 байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж зөвлөмжийг танилцуулан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан;</p> <p><i>/Тус байгууллагын хууль, дүрмээр олгосон чиг үүрэгт байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шалгах хийх эрх байдаг эсэх/</i></p>	
21	2.10.Бодлогын болон захирамжлалын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, холбогдох тайлан мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	ЗТСХ	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 7 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 заалтад нийцүүлэн ажиллахаар хяналтад авч хэрэгжилт 98,8% буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй гэж үзэж байна. Монгол Улсын 5 хуулийн 8 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 18 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 1 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн 4 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 3 тэмдэглэлийн 6, нийт 42 заалтыг хяналтад авч, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэн, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулан зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хянаж ажилласан бөгөөд нийт 42 заалт бүрэн хэрэгжиж 98% биелэлтэй байна.</p>	50%
22	2.11.Иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд шийдвэрлэх, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах	ЗТСХ	<p>НЗД-ын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар ажилтан, албан хаагчдаас нийт 115 өргөдөл ирснийг системд бүртгэн, 115 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног, 0 цаг, 48 минут. Өргөдлийг хандалтын төрлөөр нь ангилбал:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл - 18, - Захиргааны чөлөө хүссэн өргөдөл - 24, - Ажилд орох, чөлөөлөгдөхтэй 	70%

Д/д	Арга хэмжээ	Хариуцах хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			<p>холбоотой өргөдөл - 41, - Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл - 11, - Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл – 13 - Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл – 4 - Ажлын сахилга, хариуцлагын тухай – 2 - Бусад – 2 Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоногоор, зөрчлийн тоон үзүүлэлт 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	
23	2.12.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах, албан хаагчдыг баримт бичиг боловсруулахад "Баримт бичгийн стандарт" MNS 5140:2021 стандартыг мөрдүүлэх, хяналт тавих	ЗТСХ	<i>/Тус арга хэмжээ нь 1.3-д заасантай утга ижил, агуулгаараа давхцсан тул нэгтгэн төлөвлөж байх/</i>	50%
24	2.13.НЗЗ-ны байруудад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах	ЗТСХ	<p>Төлөвлөгөөг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын гамшгаас хамгаалах төлөвлөлтийн хэлтсээр батлуулахаар техник эдийн засгийн үндэслэл боловсруулж байна. Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшиг”, “Гал түймрийн аюул” сэдэвт танхимын болон дадлагын сургалтад нийт 45 ажилтан, албан хаагчийг оролцсон. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 399 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын удирдлага дор 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолодож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулилтад нийт 187 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцлоо.</p>	50%
25	2.14.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудас www.khangardi.mn/ болон мэдээллийн самбарт байршуулах	ЗТСХ, ИБАҮА ҮҮА	<i>/Тус арга хэмжээ нь 1.5, 2.5, 2,14-д заасантай утга ижил, агуулгаараа давхцсан тул нэгтгэн төлөвлөж байх/</i>	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
26	2.15.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих арга хэмжээнд идэвхтэй оролцох	ЗТСХ ИБАҮА ҮҮА	Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д 170 ширхэг хайлаас мод тарьж, модны арчилгаа, усалгааг хийж гүйцэтгэлээ. 2022 онд тарьсан 170 ширхэг хайлаас модны ургалт 90 хувьтай ургаж 10 см-ээр нэмэгдсэн байсныг хэлбэржүүлэлт хийсэн. <i>/Тусдаа арга хэмжээ болгон төлөвлөх шаардлагатай, ач холбогдолтой эсэхийг үнэлж үзэх, Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хамаарч тайлагнах/</i>	50%
27	2.16.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллах	ЗТСХ ИБАҮА ҮҮА	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хар тамхитай тэмцэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад нийт 45 ажилтан, албан хаагчийг хамруулсан. <i>/Тусдаа арга хэмжээ болгон төлөвлөх шаардлагатай, байгууллагын үндсэн үүрэгт шууд хамаарах ач холбогдолтой эсэхийг үнэлж үзэх, Сургалтын төлөвлөгөөнд тусгах/</i>	30%
28	2.17.Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах	ЗТСХ ИБАҮА ҮҮА	<i>/Тусдаа арга хэмжээ болгон төлөвлөх шаардлагатай, байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, ач холбогдолтой эсэхийг үнэлж үзэх, Сургалтын төлөвлөгөөнд тусгах/</i>	30%
Зорилт 3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт				
29	3.1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан, нярваар дамжуулан үзүүлэх,	ЗТСХ	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 11 агентлагт агентлаг хариуцсан 7 ахлах нягтлан бодогч, 1 тооцооны нягтлан бодогч, 4 нярваар дамжуулан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцөлөөр ханган ажиллалаа.	50%
30	3.2.Агентлагуудын санхүүгийн тайлан мэдээг, үнэн зөв хугацаанд нь гаргах, зөрчил дутагдлыг бууруулах,	ЗТСХ	<i>3.1-д заасан арга хэмжээтэй утга агуулгаараа давхцаж байгаа тул 1 арга хэмжээ болго төлөвлөж байх,</i>	50%
31	3.3.Нийслэлийн Засаг захиргааны байрууд, дэд төвүүдийн инженерийн байгууламжийн хэвийн найдвартай ажиллагааг	ИБАҮА	НЗЗ-ны 6-н байранд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны 32 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
	ханган ажиллах, гэрээний дагуу төлбөрийг төвлөрүүлэх,		үзүүлж ажиллаж байна. Гэрээт байгууллагуудын ашиглалт, үйлчилгээний төлбөрийн тооцоог сар бүрийн эхэнд нэхэмжлэхээр хүргүүлж, орлого төвлөрүүлэлтэд тулгалт хийн ажиллаж байна. <i>/Гэрээний дагуу хэдэн төгрөгийн төлбөр төвлөрүүлэхээс хэдийг төврөлүүлээд байгаа тоон мэдээлэл байхгүй/</i>	
32	3.4.Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхийн тулд шаардлагатай завсар үйлчилгээг гүйцэтгэгч компаниар чанартай хийж гүйцэтгүүлэх, хяналт тавих	ИБАҮА	Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны гадна бохирын худаг канесийг бүрэн цэвэрлэж лагийг цэвэрлэх ажлыг 2 удаагийн давтамжтайгаар хийж гүйцэтгэн, байрны инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажилласан.	50%
33	3.5.Нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдийн аюулгүй байдлыг хангах, 24 цагийн камерын хяналт тавих	ИБАҮА	НЗЗ-ны байруудын аюулгүй байдлыг хангах үүднээс жижүүр, харуул хамгаалалтын ажилтнууд камерын хяналтыг 24 цагийн турш хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд харуул, хамгаалалттай холбоотой зөрчил, дутагдалгүй ажилласан. Тухайлбал: - НЗЗ-ны 3-р байрны хяналтын 3 камер, 1 ширхэг бичигч төхөөрөмжид /NVR/ засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг ханган ажилласан. - Нийслэлийн засаг захиргааны 5Б,В байруудын 2 ширхэг бичигч төхөөрөмж /NVR/-ийг шинээр сольж сольж хэвийн ажиллагаанд оруулсан. - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хяналтын камерын 5 дугаартай бичигчийн 3 хард диск шатсаныг илрүүлж “Темпланд” ХХК-ны инженерт мэдэгдэж солиулсан. - НЗЗ-ны 2, 3, 4 дүгээр байр болон Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хяналтын камерын төхөөрөмжүүдийн нууц үгийг сольсон. <i>/Нийт хэдэн байранд хэдэн тоо ширхэг хяналтын камер байдаг болон эвдрэл гэмтлийг засаж сайжруулсан нэгдсэн тоон мэдээлэл судалгаа байхгүй болно./</i>	50%
34	3.6.Ажилтан, албан хаагчдыг хамгаалах багаж хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, хяналт тавих,	ИБАҮА	Цэвэрлэгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх үүднээс нийт байруудаас багаж, тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэсэн. Тайлант хугацаанд хивс угаагч машин 1 ширхэг, тоос сорогч 4 ширхэг, гадна талбайн дугуйтай хогийн тэрэг 11 ширхэг, сэгсрэгчтэй хувин 50 ширхэг зэрэг шаардлагатай	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			<p>хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангалаа. Тайлант хугацаанд 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр НЗЗ-ны байруудын галын аюулгүй байдал, ажлын байрны орчны аюулгүй байдал зэрэгт дотоод хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны арга зүй, гарын авлагын загварыг боловсруулж байр хариуцсан менежерүүдэд өгснөөр 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн инженер техникийн болон зоог, үйлчилгээний ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, хөдөлмөр хамгааллын дэвтэр хөтлөлийг сайжруулан ажиллаж байна.</p> <p>- 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 4-н байршилд байх зоог, цайны газруудын галын аюулгүй байдал, зоогийн газрын эрүүл ахуйн ажиллагаанд ээлжит шалгалтыг хийж, тус бүр заавар зөвлөмж өгсөн.</p>	
35	3.7.“Хөдөлмөр хамгааллын осолгүй манлайлал” ажлын байрны болзолт уралдаан зохион байгуулах	ИБАҮА	<p>Тайлант хугацаанд буюу 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн докторант судлаач Г.Эрдэнэтөгсийг урин “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж нийт 170 ажилтан, албан хаагчийг хамруулж, мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p>Мөн Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлоогоог зохион байгуулах журам”-ын дагуу Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд эрт илрүүлэг, эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан. Нийт 272 ажилтан, албан хаагч хамрагдлаа.</p> <p><i>/Болзолт уралдаан зохион байгуулсан эсэх талаар мэдээлэлгүй. Үндсэн төлөвлөсөн арга хэмжээнээс өөр ажил тайлагнасан./</i></p>	30%
36	3.8.Нийслэлийн засаг захиргааны байруудын хуралдааны танхимуудын техник хэрэгслийн хэвийн	ИБАҮА	Тайлант хугацаанд нийт 671 удаагийн хурлын заал, танхимын захиалгыг хүлээн авч, үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж, аливаа зөрчил,	30%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ	
	ажиллагааг хангах, гомдол саналгүй ажиллах		доголдолгүй хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллаа. /Уг арга хэмжээг хэрэгжсэн эсэхийг хянах шалгуур үзүүлэлтийг “Техник хэрэгслийн гэмтэл засварласан тоо” гэж тусгаж өгсөн боловч биелэлтэд <i>хэдэн төрлийн техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан, тайлант хугацаанд эвдрэл гэмтэл гарсан эсэх, тоон, чанарын судалгаагүй тайлагнасан./</i>		
37	3.9. Байруудын эзэмшлийн тохижилт, байгууламжийн шинэчлэлийн гүйцэтгэх	нийтийн талбайн ногоон арчлалт, ажлыг	ҮҮА ИБАҮА	НЗЗ-ны байруудын гаднах орчны аюулгүй байдлыг ханган өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн тухайн байруудын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж, орчны 50 метр хүртэлх 31,450 кв талбайн цас, мөс цэвэрлэх, өдөр тутмын болон дээврийн цэвэрлэгээг нийт 3120 удаа, их цэвэрлэгээг 144 удаа тус тус хийж, эхний хагас жилийн байдлаар нийт 3264 удаа гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.	50%
38	3.10. Байруудын эзэмшлийн шаардлагатай үйлчилгээг төсөвтөө гүйцэтгэх	нийтийн талбайд засвар, батлагдсан багтаан хийж	ИБАҮА	Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллалаа. Цахилгаан, сантехникийн эвдрэл гэмтэл, мужаан, сүлжээний үйлчилгээтэй холбоотой нийт 2262 дуудлагыг хүлээн авч тухай бүр шуурхай ажиллаж, хэвийн ажиллагааг хангасан. Тайлант хугацаанд дараах байдлаар засвар үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: - НЗЗ-ны 1, 2 дугаар байрны халаалтын шугам хоолой, ариун цэврийн өрөөний кабин, хэрэгцээний хүйтэн усны татах реле зэрэг гэнэтийн эвдрэл, гэмтлийг тус тус шуурхай засварлан ажиллалаа. - Газрын даргын баталсан инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийх хуваарийн дагуу гэмтлээс шалтгаалсан ус, дулааны алдагдлыг багасгахаар сар бүр НЗЗ-ны байруудын халаалт, хэрэглээний халуун, хүйтэн усны шугам хоолойг шалган хяналт тавин ажиллалаа. -Тайлант хугацаанд Нийслэлийн засаг захиргааны 2, 4-р байр болон Нийслэлийн нутгийн захиргааны төв	70%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			<p>цогцолбор байрны хүн зөөврийн болон ачааны нийт 14 цахилгаан шатны хэвийн найдвартай үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, сар бүр буюу нийт 6 удаа гэрээт байгууллагаар ашиглалт, засвар үйлчилгээг гүйцэтгүүлж, цахилгаан шатны аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа. НЗЗ-ны байрны 0,4квтын ерөнхий цитны оруулгын рубелник ХТП0478 станцын 2 сецкийн 4 ячак тасарсныг залгаж хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.</p> <p>- НЗЗ-ны 1 дүгээр байрны 2, 3 давхрын нийтийн эзэмшил, 5А байрны 1 давхрын нийтийн эзэмшилд тус тус засварын ажлыг хийж гүйцэтгэн төрийн албан хаагчдын ая тухтай ажиллах орчныг бүрдүүллээ.</p> <p>- ННЗТЦБ-нд байрлах цэвэр усны нөөцийн 90м³-н багтаамжтай савыг цэвэрлэж, ариутгалаа.</p> <p>- НЗЗ-ны 5В байрны 2 давхарт НБИХГ-ын 1 ажлын өрөөнд дээврийн борооны усны зайлуулахаас ус алдсаныг шуурхай засварлан ажиллалаа.</p>	
39	3.11.НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, дэд төв, Нийслэлийн нутгийн захиргаан төв цогцолбор байрны гадна, дотор орчинд цэвэрлэгээ, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх	ҮҮА	НЗЗ-ны 5-н байр, ННҮТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны нийт 61.395 мкв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж, 3840 удаа, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг 3840 удаа, хуваарийн дагуу их цэвэрлэгээг 144 удаа тус тус хийж гүйцэтгэсэн.	50%
40	3.12.Байруудад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг хэвшүүлэх, сайжруулах	ҮҮА	Хог хаягдлыг хуванцар, лаазаар нь 2 ангилж нийт 130кг хуванцар сав, 20кг лаазыг ангилан бэлтгэж хог тээвэрлэлтэд ачуулсан.	50%
41	3.13.Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээг төрийн албан хаагчдад үзүүлэх	ҮҮА	Тайлант хугацаанд Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар театр, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны цайны газруудаар дамжуулан давхардсан тоогоор 39776 хүнд нийтийн хоолны үйлчилгээг стандартын дагуу, эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр бэлтгэн, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн, нийт 590,359.0 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллалаа. Хангарди ордны зоогийн газрын хоол үйлдвэрлэлийн технологийн картыг зууш салат- 20, хачир сүмс - 8, нэгдүгээр хоол - 20, хоёрдугаар хоол – 40, өглөөний цай – 10 буюу нийт 98 төрлийг багтаан боловсруулж зоогийн	50%

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
			газрын өдөр тутмын үйл ажиллагаанд хуваарийн дагуу мөрдөн ажиллаж байна.	
42	3.14.Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, хээрийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх	ҮАА, ИБАҮА	Тайлант хугацаанд нийт 98 удаагийн хурлын цайны завсарлага, хүндэтгэлийн хүлээн авалтаар нийт 6343 хүнд хурдан шуурхай, чанартай зоогийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа. <i>/Үндэсний баяр наадмын бэлтгэл ажлыг хангах болон зохион байгуулах ажилд хэрхэн оролцсоноо тайлагнах/</i>	50%
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт				
43	4.1.Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, үр дүнд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ЗТСХ	Газрын даргын 2023 оны 01 сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 01 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд НЗЗ-ны байруудад ажиллаж буй ННЗБ-ын албан хаагчдаас цэвэрлэгээ, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг 85 төрийн албан хаагчаас авсан. Судалгааны дүнд 55.2% нь сайн, 38.8% нь дунд, 6% нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар судалгааны төслийг боловсруулан ажиллаж байна. <i>/судалгааг ямар аргаар авсан, үр дүнгийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлагнах, үр нөлөөг үнэлэх/</i>	50%
44	4.2.Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	ЗТСХ, ИБАҮА, ҮАА	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 захирамжаар батлагдсан “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх ажлын нэгдсэн төлөвлөгөө”-нөөс холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа нийцүүлэн мөрдөж ажиллалаа. <i>/Хууль тогтоомжийн хэрэгжилтээр тайлагнах/</i>	50%
45	4.3.Засгийн газрын 2021 оны 07 дугаар тогтоолын дагуу шаардлагатай холбогдох арга хэмжээг авч ажиллах	ЗТСХ ҮАА, ИБАҮА	Эдгээр арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй бөгөөд “Тус арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа болоогүй болно.” тайлбар бичсэн боловч Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжих хугацааны үзүүлэлтэд I-IV хугацаанд төлөвлөсөн.	-
46	4.4.“Улаанбаатар 2023” Зүүн Азийн наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг ханган хамтран ажиллах, оролцох	ЗТСХ		
47	4.5.“Цахим Улаанбаатар” төсөл, “digital first” аяны үйл	ЗТСХ ҮАА,		

Д/д	Арга хэмжээ	Хариуца х хэлтэс	Дүн шинжилгээ	Үнэлгээ
	ажиллагаанд ажилтан, албан хаагчдыг уриалан идэвх санаачилгатай оролцох	ИБАҮА		
48	4.6.Цахим хөгжлийн багц хуулийг боломжит мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	ЗТСХ		

2.Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланд Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилтын 11 арга хэмжээ, нийтлэг чиг үүргийн 1 зорилтын 17 арга хэмжээ, дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 1 зорилтын 14 арга хэмжээ, төрийн албаны чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 1 зорилтын 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Нийт 48 арга хэмжээнээс 42 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 48.5% -ийн явцтай (Эрчимжүүлэх шаардлагатай) үнэлэгдэв.

Зорилтот түвшин шалгуур үзүүлэлтдээ хүрээгүй, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 9 арга хэмжээ байгаа ба цаашид үлдсэн 5 сарын хугацаанд үйл ажиллагааны явцыг эрчимжүүлэн ажиллах, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтдээ ойртуулах, улмаар хүргэх шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцохдоо төлөвлөлтөд алдаа гарсан, хэт ерөнхий, хэмжих боломжгүй, чанарын болон тоон үзүүлэлтийг хангалтгүй тусгаснаар дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг зөв тодорхойлох, тайланд хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой тусгаж байх шаардлагатай байна.

1.Нийт 48 арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэрийн тусгаагүй. Төлөвлөгөөний баганад төсөв /Төсөв (сая)/ байхад төлөвлөгөөний биелэлтийн баганад /Төсөв (мян.төг)/ болгож хэмжих нэгжээ өөрчилсөн. Байгууллагын үйл ажиллагааны зардалд нийт хэдэн төгрөгийн төсөв тусгагдсан талаар мэдээлэлгүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд санхүү төсөв тавигдаагүй. /Сургалт, ажилчдын цалин хөлс, нийгмийн баталгаа, худалдан авах ажиллагаа гэх мэт/

2.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөх ёстой боловч зорилтоос өөр арга хэмжээг төлөвлөсөн.

3.Гүйцэтгэлийн хэрэгжилтийг тайлагнах загварыг өөрчлөхгүй байх,

3.Ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай арга хэмжээг нэгтгэн 1 арга хэмжээ болгон төлөвлөөгүй.

Арга хэмжээ 2.12 “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах, албан хаагчдыг баримт бичиг боловсруулахад "Баримт бичгийн стандарт" MNS 5140:2021 стандартыг мөрдүүлэх, хяналт тавих”,

Арга хэмжээ №1.3 “Албан бичгийг тоон гарын үсгээр илгээх, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулж хэвшүүлэх, зөрчлийн тоог бууруулах”/ -1 арга хэмжээ болгон төлөвлөх,
Арга хэмжээ №1.6

Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах,

Арга хэмжээ №1.10 “Ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах 2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах”,

Арга хэмжээ №2.7 “2023 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах” -1 арга хэмжээ болгон төлөвлөх,

Арга хэмжээ №1.5

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах журмын дагуу мэдээллийг цахим системд цаг хугацаанд байршуулж хэвших

Арга хэмжээ №2.5

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь тайлагнаж ажиллах

Арга хэмжээ №2.14

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудас www.khangardi.mn болон мэдээллийн самбарт байршуулах-1 арга хэмжээ болгон төлөвлөх,

Арга хэмжээ №3.1

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан, нярваар дамжуулан үзүүлэх,

Арга хэмжээ №3.2

Агентлагуудын санхүүгийн тайлан мэдээг, үнэн зөв хугацаанд нь гаргах, зөрчил дутагдлыг бууруулах-1 арга хэмжээ болгон төлөвлөх,

4.Нийт 48 арга хэмжээнээс:

- Тоон үзүүлэлтээр хэмжихээр төлөвлөсөн-19 арга хэмжээ байна.

1. 1.1-д Дотоодын бүтээгдэхүүний эзлэх хувь,
2. 1.3-д Зөрчлийн тоо,
3. 1.10-д Авлига, ашиг сонирхолын зөрчлийн тоо-0,
4. 2.1-д гаргасан судалгааны тоо,
5. 2.3-д гүйцэтгэл үр дүнг үнэлсэн тоо,
6. 2.6-д цалин бодож олгосон тоо,
7. 2.7-д Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо,
8. 2.8-д Зөрчлийн коэффициент,
9. 2.11-д Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд гарсан зөрчил,
10. 2.13-д Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн тоо,
11. 2.15-д Арга хэмжээний тоо,

12. 2.16-д Сургалт, мэдээллээр ханган ажилласан тоо,
13. 2.17-д Сургалт, мэдээллээр ханган ажилласан тоо,
14. 3.5-д байруудад гарсан зөрчлийн тоо,
15. 3.8-д Техник хэрэгслийн гэмтэл засварласан тоо,
16. 3.9-д Тохижилт, ногоон байгууламж хийгдсэн тоо,
17. 3.11-д Цэвэрлэгээ, үйлчилгээ хийх талбайн хэмжээ /м2/,
18. 3.12-д Ангилан ялгасан хог хаягдлын хувь,
19. 4.1-д Сэтгэл ханамжийн судалгааны тоо,

- Чанарын үзүүлэлтээр хэмжихээр 1 арга хэмжээ- “2.5-д өр авлагагүй ажилласан байна”

- 28 арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “Үйл ажиллагааны хувь”-иар үнэлэхээр төлөвлөсөн нь хэт ерөнхий, хэмжих боломжгүй, эдгээр арга хэмжээг хийж хэрэгжүүлснээр анх байснаасаа ахиц өөрчлөлт гарсан эсэхийг, ямар түвшинд хүрснийг тодорхойлж хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байна. Төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийг хэдий чинээ тодорхой, хэмжиж болохуйц, бодитой тусгана төдий чинээ хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг нарийн хэмжиж боломжтой болно.

5.Төлөвлөгөөний хэрэгжих хугацааны үзүүлэлтийг бүх арга хэмжээнд I-IV улиралд буюу бүтэн жилдээ хэрэгжихээр заасан нь хэт ерөнхий төлөвлөсөн, эхний хагас жилийн байдлаар биелэлтийг тайлагнахдаа 4.3,4.4,4.5,4.6 дугаар арга хэмжээг хугацаа болоогүй төлөвөөр тайлагнасан. Угтаа төлөвлөгөөний дагуу бол хэрэгжиж байх хугацаа юм.

6.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги төлөвлөгөө, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт үндэслэсэн байх шаардлагатай ч төлөвлөгөө болон биелэлтэд эдгээр мэдээлэл байхгүй. Угтаа бол тэдгээр баримт бичиг нь гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийн хавсралт болох ёстой юм.

7.Нийслэлийн Засаг даргын 2022.01.27-ны өдрийн А/93 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дүрэмд тус газрын үндсэн чиг үүргийг 6 заалтаар үүрэгжүүлж өгсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дүрмээр хүлээсэн чиг үүрэгт хамаарах 14 арга хэмжээг төлөвлөсөн. Цаашид дүрмээр хүлээсэн 6 үндсэн чиг үүргийг төлөвлөж биелэлтийг нь гаргах,

8.Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд үндсэн зорилго, зорилтдоо чиглээгүй.
/Жишээ нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд 1.5,1.6,1.7,1.8,1.11 гэсэн нийт төрийн байгууллагуудын хэрэгжүүлдэг арга хэмжээ /хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт/ орсон.

9.Тоон мэдээлэл, Судалгаа шинжилгээнд суурилагагүй.
/Жишээ нь байгууллагын 2022 оны албан бичиг шийдвэрлэлтийн зөрчлийн тоо 11, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчлийн тоо 14 байсан гэж суурь түвшинг тодорхойлж, 2023 онд хүрэх түвшинг зөрчлийн үзүүлэлтийг “0” болгоно гэж төлөвлөсөн нь хэт утопи төлөвлөлт болсон ба 1 зөрчил үүссэн тохиолдолд уг арга хэмжээний хэрэгжилт бүхэлдээ “0” болох эрсдэлтэй юм. Угтаа бол 2023 онд зөрчлийн тоон үзүүлэлтийг 5 болгож, 35%-аар бууруулна гэж төлөвлөсөн бол бодитой байх байлаа./

10.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний хувь, хэсгийн дундаж хувь, нийт арга хэмжээний дундаж хувийг тооцож гаргаагүй.

11.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа холбогдох алба, хэлтсээс санал аваагүй. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулагдах ёстой байтал хоорондоо уялдаа холбоогүй.

12.Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн хариуцах арга хэмжээ нийт үйл ажиллагааны 52.08 хувийг эзэлж, үндсэн үйл ажиллагаа буюу дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хувь нийт арга хэмжээний 22 хувийг эзэлж байна. Цаашид төрийн байгууллагууд нийтээр хэрэгжүүлдэг арга хэмжээнээс илүү байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг түлхүү төлөвлөж өгөх нь зохимжтой болно.

13.Тайлангийн бичвэрийг 2000 /хоёр мянган/ тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах, шаардлагатай нотлох баримтыг хавсаргах /Тухайн чиглэлийн төлөвлөгөө, биелэлт, холбогдох судалгаа, тоо мэдээ, зураг гэх мэт/

14.Тухайн чиглэлээр хийгдсэн ажлыг бүрэн хамруулах,

15.Биелэлтийг захиргааны ахлах мэргэжилтэн, хэлтсийн даргаар хянуулан, газрын даргад танилцуулан албажуулж хэвшихийг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Л.ДЭЛГЭР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЗОЛБАЯР

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Б.УУГАНЦЭЦЭГ